



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 15

Мандалговь

2017 оны орон нутгийн төсөвт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дах заалтууд, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 5,179,239,8 мянган төгрөгөөр нэгдүгээр хавсралтаар, 2017 оны ерөнхий орлогын эхний үлдэгдэл 1,257,027,5 мянган төгрөгөөр, 2017 оны ОНХСангийн эхний үлдэгдэл 662,584,9 мянган төгрөгөөр хосёрдугаар хавсралтаар, хандив тусламж 260,600,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт орлогын эх үүсвэрийг 7,359,452,2 мянган төгрөгөөр баталсугай.

2. Аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогыг 1,846,762,9 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 22,745,811,7 мянган төгрөгөөр, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг 5,718,962,4 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

3. 2017 оны орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар 11,185,153,2 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага санхүүжилтийг дөрөвдүгээр хавсралтаар 22,895,508,8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг тавдугаар хавсралтаар 3,499,247,2 мянган төгрөгөөр, нийт зарлага санхүүжилтийг зургаадугаар хавсралтаар 37,579,909,2 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

4. 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг долдугаар хавсралтаар 1,673,343,8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг наймдугаар хавсралтаар 520,224,4 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

5. Орон нутгийн төсөл сангуудын 2017 оны төлөвлөгөөг 3,887,358,4 мянган төгрөгөөр есдүгээр хавсралтаар баталсугай.

6. Батлагдсан төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, зарлага санхүүжилтийг хууль журамд нийцүүлэн зарцуулж тайлагнахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100003